

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ХҮНИЙ ЭРХ БА АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

ХУУЛИЙН ХАМГААЛАЛТ ШААРДЛАГАТАЙ БАЙНА!!!

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ХҮНИЙ ЭРХ БА АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

ХУУЛИЙН ХАМГААЛАЛТ ШААРДЛАГАТАЙ БАЙНА!!!

ЭРХ БАРИГЧИД албадан нүүлгэлтийн асуудлаарх олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хууль тогтоомжиндоо тусган амьдралд хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хууль ёсны эрх хэмээн хүлээн зөвшөөрч, хуулиар баталгаажуулан хамгаалах**
- Албадан нүүлгэхийг хориглох, аливаа байдлаар нүүлгэхийн өмнө дараах арга хэмжээг заавал авах тухайлан,**
 - Нүүлгэн шилжүүлэх бүхий л боломжит хувилбарыг тодорхойлохын тулд нөлөөллийн бүсэд хамрагдаж буй иргэдтэй зөвшилцөх үйл явцыг хуульчлах
 - Нүүлгэхээс өмнө нөлөөлөлд өртөх иргэдэд зориулсан үнэн зөв, үндэслэлтэй мэдэгдэл өгөх
 - Санал болгож буй нүүлгэн шилжүүлэлтийн нөхцөлд дахин суурьших газар, орон байрны боломжит хувилбарын тухай мэдээллээр хангах
 - Нүүлгэх явцад хөндөгдөх аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын арга хэмжээ авах
 - Шаардлагатай тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хуулийн заалтуудыг бий болгох
 - Бүхий л алдагдалд нөхөн төлбөр олгох талаар тодорхой заалтуудыг хуулиндаа тусгах
- Өөрийн улс дахь орон байрны нөхцөл байдалд үр дүнтэй мониторинг хийх механизм бүрдүүлэх. Тус механизмаар эзэмшлийн баталгаат байдлын наад захын төвшин хангаж чадахгүй байгаа, орон гэргүй болон шаардлага хангаагүй орон сууцанд амьдардаг, зохистой орон байраар хангагдах эрхээ таньж мэдэх боломжгүй хүн, нийгмийн бүлгийг тодорхойлох, тэднийг албадан нүүлгэх, айлгах бусад байдлаар сүрдүүлэхээс хамгаалах**
- Нөлөөлөлд өртсөн иргэдтэй зөвлөлдөх үед тухайн үеийн байдлаар эзэмшлийн эрхийн наад захын төвшинд хүрэхгүй байгаа хүмүүст эрх зүйн орчны хамгаалалт тогтоож өгөхийн тулд дараах арга хэмжээг авах тухайлан,**
 - Эзэмшлийн баталгаат байдлыг тогтооход саад учруулж буй болон хууль ёсны тэгш хамгаалалтыг үгүйсгэсэн аливаа хууль, дүрэм журмыг хянан үзэх, тодорхой хугацаанд шинэчлэн сайжруулах
 - Эзэмшлийн эрхийг хууль ёсны байлгах боломжтой нөхцөлийг тодорхойлох
 - Хуулийн дагуу зохицуулах боломжгүй байршилд амьдарч буй иргэд, ялангуяа байгалийн аюултай болон эрүүл мэндэд аюултай орчинд амьдарч буй иргэдийг нэн тэргүүнд дахин байршуулах
- Зан заншил уламжлалд нь тохирсон, нийгмийн суурь үйлчилгээ ба дэд бүтцийн хүртээмжтэй байх шаардлага хангасан байрлалтай орон байрны “зохистой” стандартыг нэвтрүүлэхийн тулд тухайлан,**
 - Орон нутгийн эрх бүхий байгууллагууд аливаа шинэ орон сууц барих эсхүл олон нийтийг дахин байршуулахдаа эдгээр стандартыг хангах
 - Олон улсын стандартад нийцсэн байхыг баталгаажуулахын тулд одоогийн мөрдөж буй стандартыг даруй хянаж үзэх
 - Төлбөрийн чадвараасаа үл хамааран ямар ч хүн хувийн болон орон нутгийн хэрэглээний цэвэр ус, эрүүл ахуйн наад захын шаардлага хангасан үйлчилгээнээс ангид үлдэх ёсгүйг баталгаажуулах
- Стандартын шаардлага хангаагүй орон сууцны нөхцөл байдлыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх, нэн ялангуяа эмзэг бүлгийнхэнд болон амь нас, эрүүл мэндэд нь эрсдэлтэй хэсгийн хүмүүст тэргүүлэх ач холбогдол өгөх
- Орон сууцны нөхцлийг дэвшилттэйгээр сайжруулах, нийгмийн бусад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог хангах, ялангуяа эмзэг бүлгийнхэний асуудлыг шийдвэрлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх**
- “Орон байрны асуудлаарх үндэсний стратеги” батлах ажлыг нэн даруй эхлүүлэх**
- Эрх бүхий байгууллага нь хуулиа мөрдөж байгааг баталгаажуулахын тулд уг газруудад хяналт тавих үр дүнтэй механизмыг үндэсний ба орон нутгийн хэмжээнд хуульчлах, хэрэгжилтийн мониторинг хийх**
- Эрх нь зөрчигдсөн хүмүүсийн эрхийг сэргээх хууль эрх зүйн үр дүнтэй арга хэрэгслээр хангах**

Монгол улсын хууль нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн тухай гэрээ хэлэлцээр, түүний дотор Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакттай нийцэж байх ёстой.